

## **“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр № 1

Арвайхээр сум

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” хувьцаат компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан тайланг хангалттай гэж үзэссүгэй.



A handwritten signature is placed over the stamp, consisting of a stylized 'A' and a long, sweeping line extending to the right.

# **“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

№ 2

Арвайхээр сум

## **Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр

1. Д.ЭНХБАТ
2. М.НИНЖБАДГАР
3. Ж.САМДАНЖИНМЭД
4. О.БАТЖАРГАЛ
5. Д.НЭМЭХБАЯР
6. Ю.БАТСАЙХАН
7. Б.БАЯСГАЛАН

Хараат бус гишүүдээр

8. Т.БАДРАХБАЯР
9. З.ДАШЗЭВГЭ
10. Л.ПУРЭВ

11. Г.БАТСҮХ нар тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдоныг баталсугай.



**“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр № 3

Арвайхээр сум

**Аудитын хорооны тайланг батлах тухай**

“Баянтээг” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дунг үндэслэн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн Аудитын хорооны тайланг хангалттай гэж үзэссүгэй.
2. “Баянтээг” ХК-ийн Аудитын хорооны 2014 оны тайланг хавсралтаар баталсугай.



“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРООНЫ ДУГНЭЛТ

2015 оны 7.. сарын 5.. өдөр

“Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо нь компаний тухай хуулийн 81.4 дүгээр зүйлийн дагуу үйл ажиллагаанаа явуулсан бөгөөд “Баянтээг” ХК-ний санхүүгийн тайланд 2014 оны 12 дугаар сарын 31 байдлаар аудит хийж дүгнэлт гаргалаа.

“Баянтээг” ХК нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуй нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бэлтгэгдсэн байна.

“Баянтээг” ХК нь Өвөрхангай аймгийн Аудитын газраар сүүлийн 3-н жил санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэжээ.

2014 оны байдлаар их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийгдээгүй гэж үзэв. Мен гэрээ хэлцэлийг ашиггүй хийснээс болоод алдагдал хулээгээгүй болно.

“Баянтээг” ХК-ий НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж, санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл, тайлан журналыг тогтмол хөтөлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллах нь зүйтэй байна.

Байгууллага авлага, өглөгийг санхүүгийн тайланд тусгах талаар бодлогын баримт бичигтүйн улмаас олон жил хуримтлагдан бүртгэгдсэн 86,0 сая төгрөгийн найдваргүй авлага зардал болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн байна.

Иймд цаашид авалгын бүртгэлийн талаар бодлогын баримт бичигт тусгаж, найдваргүй авалгын нөөц үүсгэж байх нь зүйтэй гэж үзэж байна.

ДАРГА З.ДАШЗЭВЭГ

## **“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

№ 4

Арвайхээр сум

### **ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зардлын төсвийн тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дах заалтыг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн ТУЗ болон Гүйцэтгэх Удирдлагын 2015 оны төсвийг 5,779,000 төгрөгөөр тогтоосугай.



A handwritten signature in black ink, appearing to be "Д.Сүрэнжавжав", is placed next to the stamp.

## **“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2014 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

№ 5

Арвайхээр сум

### **Компанийн ногдол ашгийн тогтоолыг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. ТУЗ-ийн 2014 оны ногдол ашгийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг тараах өдрийг 2015 оны **06** сарын **01**-өдрийн дотор тараахыг зөвшөөрсүгэй.



A handwritten signature in black ink, appearing to read "Д.Сүрэнжавын".

## **“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2014 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

№ 6

Арвайхээр сум

**Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг  
батлах тухай**

“Баянтээг” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.



A handwritten signature in black ink is placed next to the seal. The signature appears to be "Доржсүрэн" (Dorjsuren).